

БГД-ийн Эрдмийн өргөө цогцолбор сургуулийн 5-р ангийн сурагчдын дунд зохион явуулсан

“Икс өв компьютерийг хэн сайн эзэмшсэн бэ?” уралдааны тайлан 2010 оны 5 сарын 12 Тус

сургуулийн 5-р ангийн 6 бүлгийн 199 сурагч икс өв компьютерийг 1,5 жилийн хугацаанд сургалтандаа ашиглаж, түүнээс олон зүйлийг сурч, мэдэж, эзэмшиж, оорсдийн сурсан мэдсэнээрээ тайлан тавилаа.

Үүнд: “Муужгай”, “Зурах”, “Цээжлэх”, “Тооцоолох”, “Бичих” программ дээр нэг бүлгээс таван сурагч нийт 6 бүлгийн 30 сурагчийн дунд уралдаан зохион явуулав. Програм тус бүр дээр хийгдсэн ажил болон түрүүлсэн сурагчдыг дурьдвал:

1. “Муужгай” програм дээр алхан хээг хийх- 5а ангийн сурагч Б.Дэлгэрморон
2. “Зурах”-5а ангийн сурагч Ц.Бямбажав
3. “Цээжлэх” шинээр тоглоом үүсгэх - 5г ангийн сурагч Д.Анужин
4. “Тооцоолох” энгийн болон аравтын бутархайн хавсарсан илэрхийлэл бодох - 5г ангийн сурагч Ж.Бэрцэцэг
5. “Бичих” түргэн бичлэгийн уралдаан -5г ангийн сурагч Н.Ариунцэцэг нар бусдыгаа тэргүүллээ.

Мөн бичих програм дээр хийсэн зүйлээ флашинд хуулж, хэвлэж гаргах ажлыг сурагч Уянга хийж бусад сурагчиддаа үзүүллээ.

Түүнчлэн сурагчдын бүтээлээр үзэсгэлэн гаргаж сургуулийн нийт сурагчдад хүртээл болгосон нь бусад сурагчдын икс өв компьютерийг эзэмшин суралцах хүсэл тэмүүллийг торүүлсэн сайхан ажил боллоо.

Икс өв компьютерийг сургалтанд хэрэглэснээр сурагчдын хичээлд оролцох, сурах идэвхи сайжирснаар сурлагын амжилт, чанарт ахиц гарлаа.

Тайланг бичсэн: 5-р ангийн секцийн ахлагч багш Минжээ